



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН
ТУШААЛ**

2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар А/143, А/376

Улаанбаатар хот

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС
ОЛГОХ ПРОТЕЗ, ОРТОПЕДИЙН ЖИШИГ ҮНЭ БАТЛАХ ТУХАЙ**

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

- 1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг хавсралт ёсоор баталсугай.
- 2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /А.Өнөржаргал/-т, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт тус тус даалгасугай.
- 3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/507, А/112 дугаар хамтарсан тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.
- 4.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЧИНЗОРИГ